



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 562

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зарласан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Б.Гаваа, Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, ахлах мэргэжилтэн В.Дарханбаатар нарыг томилсугай.

2. Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч нарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн
562 дугаар тогтоолын хавсралт

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

1. Компанийн 2018 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлан болон зардлын төсвийн гүйцэтгэлтэй танилцан, гүйцэтгэх удирдлагад чиглэл өгч шийдвэр гаргах;
2. Компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны зардлыг баталж, зардлыг Шинэ нисэх буудлын үйл ажиллагаа жигдэрч, зохих орлогоос санхүүжих хүртэл хугацаанд Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу Монголын талын гаргах эхлэлтийн хөрөнгө болох 17.1 сая ам.долларын ажлын жагсаалтад тусган санхүүжүүлэх асуудлыг ИНЕГ-т тавьж шийдвэрлүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох.

-----oOo-----